

ЗҮҮН ХОЙД АЗИЙН БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖИЛ ДЭХ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ, ЗОРИЛТ

Лю Зян

Өнөөдөр Зүүн хойт Ази (ЗХА)-ийн бүс нутгийн 5 орны хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид “Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж, ЗХА-ийн бүс нутгийг хөгжүүлэхэд түлхэц болох нь” сэдвээр ярилцсан нь маш хэрэг тустай чухал зүйл болсон юм.

XXI зуун бол дэлхийн эдийн засгийг цаашид нэгэн цогц болгон хөгжүүлэх цаг үе, дэлхийн соёлыг даяарчлан хөгжүүлэх цаг үе, мөн олон нийтийн хэвлэл мэдээллийн соёлыг ирээдүйд олон хэлбэрээр хөгжүүлэх цаг үе мөн.

ЗХА-ийн бүс нутгийн аливаа улс орон нийтээрээ хөгжих явцад бүс нутгийнхаа эдийн засаг, соёлын хамтын ажиллагааныхаа үндэс суурийг тасралтгүй бэхжүүлэн, бүс нутгийнхаа эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэхийн сацуу бүс нутгийнхаа эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хэвлэл, мэдээллийн орчинг идэвхтэй бий болгох шаардлагатай.

“ЗХА-ийн бүс нутгийн Засгийн газрын тэргүүн нарын нийгэмлэг”-ийн гишүүд, тэдгээрийн хэвлэл мэдээллийн байгууллагууд шинэ, чухал мэдээлэлтэй байгаа, тухайлбал: Японы Тоттори муж, Солонгосын Ганвон муж, Монгол Улсын Төв аймаг, ОХУ-ын Приморийн хязгаар, Хятадын Жилинь мужийн орон нутгийн төв хэвлэл нь ЗХА-ийн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн цаашдын хөгжилд нийтээрээ хариуцлага хүлээж, үүрэг гүйцэтгэх боллоо.

XX зууны дунд үеэс хойш, дэлхийн хэв журмыг даган мөрдөж, улс орны хоорондын харилцаа хийгээд бүс нутаг хоорондын шинэ үзэл баримтлал, тасралтгүй үргэлжилж буй шинэ үзэл санаа, энх тайван, аюулгүй байдал, нийтийн хөгжлийн талаар санал сэтгэгдлээ хуваалцан солилцож ирлээ.

Энэхүү үндсэн мэдлэгийнхээ дор, дэлхий нийтээрээ олон ургальч үзлээр тал бүрээс нь хамгаалан дэмжиж, олон янзаар хөгжүүлэх чиг хандлагаар санал боллоо солилцож байсан. Хамтран ажиллах хүсэл итгэлтэй байж, хамтран ажиллах нээлттэй онолоор, эрх тэгш хамтын ажиллагааны байр суурь, олон талын хамтын ажиллагааны хэлбэр аяндаа үүсэн бий болсноор тухайн үеийн олон улсын улс төр, эдийн

засаг, соёлын харилцааны шинэ онцлог биеллээ олсон юм. Энэ хугацаанд харилцан адилгүй олон шат давхаргад олон янзын бүтэцтэй, бүс нутгийн шинжтэй эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг янз бүрээр хэт ихээр өрнүүлж, хүн төрөлхтөн дэлхийд нутаг дэвсгэрийн хязгааргүй бүтээлч хүч, урам зоригийг хөгжөөн дэвжээж бий болгосон билээ. “ЗХА-ийн бүс нутгийн Засгийн газрын тэргүүн нарын нийгэмлэг”-ийн гишүүд бүс нутгийн хооронд эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсоноор ЗХА-ийн нутаг дэвсгэрт хамтын ажиллагааны үндсэн хүрээ бүрэлдэн тогтож, Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны хэлбэр, түүний адил төстэй цогц байдал, ЗХА-ийн нутаг дэвсгэрийн хоорондын эдийн засаг, соёлын хөгжлийг тодорхойлсон харилцаа амжилттай хэрэгжиж, ЗХА-ийн нутаг дэвсгэрт эдийн засаг, соёлын хамтын ажиллагаагаа идэвхтэй хөгжүүлэх үүрэг, ач холбогдлыг дээш өргөн, өргөжүүлэн хөгжүүлэх нь чухал болсон юм. Азийн нутаг дэвсгэрийн хамтын ажиллагаа харилцан адилгүй, маш их ялгаатай, иймээс харилцан санал бодлоо хуваалцан, бие биенээсээ харилцан хамааралтай оршин тогтнох, эдийн засаг, соёлын харилцааг бий болгон хөгжүүлэх, түүнийгээ цаашид улам өсгөн нэмэгдүүлж, хамтран зохицуулах, хүрээгээ улам тэлэх, тогтолцоог дээд шатанд гаргах, үндэстэнээ дээдлэн, нутаг дэвсгэрээ түшихийг бид ерөнхий утгаар нь соёлын хамтын ажиллагааг дээдлэн хөгжүүлэх гэж нэрлэж байна.

Хэвлэл, мэдээллийн салбарын нэрт эрдэмтэн Масер Макехуханы /дуудлагаар.- Орч./ хэлсэн: “Хэвлэл мэдээлэл нь хүний насыг уртасгадаг” гэсэн алдартай үг бий. Тэрбээр: “Онцсон техникийн эрин үед бидний бие агаарын орон зайн хүрэн дотор өслөө. Өнөөдөр олон зууныг дамжиж өнгөрсөн цахилгаан техникийг хөгжүүлж, бидний мэдрэлийн төв систем бас уртаслаа. Эдүгээ хүртэл бид дэлхийн бөмбөрцгийг тогтоон барьж, сансар огторгуйд хүрч цаг хоорондын ялгаа, агаарын орон зайн ялгааг арилгаж байна” гэж хэлсэн билээ. Хүмүүс Макехуханы хэлсэн хэвлэл мэдээллийн талаархи онолд зарим нэг маргаантай зүйл бий хэмээн ярьсгааж л байдаг, гэвч Макехухан эрин үеийн хөгжил, нийгмийн хөгжил, хүн төрөлхтөний сэтгэл зүйн хөгжил дэх олон нийтийн мэдээллийн хэрэгслийг чухалчлан үүрэг, ач холбогдлыг илрүүлэн нээж, гаргаж тавьсанд түүний онолын хувь нэмэр оршино. Макехухан бол хэвлэл мэдээллийн техникийн хэрэгслэлийн тухайд зүгээр нэг ярьсан юм бишээ, хүнд дамжуулан хүртээх техник хэрэгслэлийн хүчин чадлыг уртасган нэмэгдүүлэх талаар таниулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн шуурхай мэдээг бэлтгэн боловсруулах, хүний сэтгэлд хүргэх соёлын ур чадварыг

бий болгох талаар тодорхойлж, нийгмийн ухамсрыг өөрчлөх болон хүн төрөлхтөний мэдлэг олж авах арга барилыг гүнзгийрүүлэн лавшруулж, түүнд нөлөөлөх, эдгээр нөлөө нь магадгүй хүн төрөлхтөний үйл ажиллагаа, бодит амьдралд хэрэгжин, өөрөө боломжийн хирээс хэтэрсэн туршлага хуримтлуулах, техникийн боломжийг даван хүрээг тэлж, хөгжүүлэх улмаар хязгааргүй уудам огторгуйн орон зайд соёл иргэншлийн ололт амжилтыг бүтээн байгуулах тухай ярьсан гэж бид ойлгож байна. Хагас зуун жилд хүн төрөлхтөний нийгэмд олон нийтийн мэдээллийн нөлөөнд хөгжин хувьсаж, Макехуханы үзэл санаа шалгаран хэрэгжиж, даяарчлалын мэдээ түгэн тарж, соёлын хамтын ажиллагааг дээдлэн, нэгэнт дэлхийн шинжтэй хөгжлийн давалгаа болжээ.

Энэ нь бидний өнөөгийн дэлхийн эдийн засгийн хөгжил болон дамжуулан дэлгэрүүлэх хөгжлийн үзэл баримтлалын орчин агаад хэрэгжүүлэн, дамжуулах түгээх орчин зайлшгүй мөн. Ийм орчинд тус нийгэмлэгийн гишүүн тус бүр бүс нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал үзэл санааг цаашид хэрэгжүүлэн хөгжүүлэхэд түлхэц болох юм.

Юуны өмнө эдийн засаг, соёлын хамтын ажиллагаа, харилцааны салбарыг бүтээн байгуулахын сацуу бас эдийн засаг, соёлын үзэл санааг эн тэнцүү зэрэгцүүлэн тавьж, хэлбэржүүлэх хэрэгтэй байна. Эдийн засаг, соёлын үзэл санаа нь эдийн засаг, соёлоосоо, өөрөөсөө бүрэн дүүрэн тогтож, хэлбэржих бус, түүний эдийн засаг, соёлын мөн чанарын үнэ өртгийг томъёолон тэмдэгжүүлэхээс бүхэлдээ шалтгаалан үүсдэг. Мөн түүнчлэн эдийн засгийн үнэ өртгийг авах, өртгийг тодорхой тайлбарласнаар эдийн засаг, соёлын үзэл санааны мэдээллийн хэлбэр байдал бүрэлдэн тогтоно. Мэдээлэл нь таних тэмдэг үзүүлэлтийн үзэл санаатай байж сая ашиглагдана. Мэдээлэл нь дамжуулан түгээх үзэл санаатай байж сая хэрэглэгдэнэ. Харин эдийн засаг, соёлын үзэл санааг зөвхөн томъёолон, дамжуулж түгээснээр сая өргөн олон түмэн хүлээн авч, нийтийн хүртээл болно. Сонинг багтаагаад олон нийтэд тархсан хэвлэл мэдээлэл нь нийгмийн мэдээний боловсруулалтын бүтэц, тархалтын бүтэц нь бүс нутаг дахь хамтын ажиллагааны хооронд эдийн засаг, соёлын үзэл санааг хэрэгжүүлэн нийтийн хүртээл болгох явцад хэвлэлийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа улмаар өөр өөр харилцан адилгүй бүс нутгийн эдийн засаг, соёлын мэдээг бүхэлд нь нийтэд дамжуулан тараах хэмжээнд хэрэглэх, эдийн засаг, соёлын талын өртгийн мэдлэгийг тодорхой тайлбарлах, өнгөт фото зургийн системийг өргөн ашиглах,

саналаа солилцох, хоорондоо адилгүй бүс нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын амьдралыг бүх нийтийн үзэл санаагаар дүүргэвэл зохилтой. Бүх нийтийн хөгжлийн хамтын ажиллагаа, харилцааг иймэрхүү маягаар нутаг дэвсгэрт эдийн засаг, соёлын үзэл санааг бий болгож хэрэгжүүлэх, үндэс суурийг тавьж, бүс нутаг дахь шинэ мэдээг хэвлэлийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан ийм төрлийн эдийн засаг, соёлын үзэл санаанд хүрч, улмаар дээрхи бүс нутгийн нийгэмд чадварлагаар хэрэгжүүлэн, тараан түгээх явдал чухал юм. Эдийн засаг, соёлын салбарын мэдээг олон нийтийн хүртээл болгосноор эдийн засаг, соёлын үйл хэргийг нийтээрээ хөгжүүлэхэд түлхэц болно.

Дараа нь эдийн засаг, соёлын хамтын ажиллагаа, харилцааны салбарыг бүрэлдүүлэн тогтоож чадахын зэрэгцээ түүнчлэн эдийн засаг, соёлын ур чадвараа харилцан нөхөх орон зайг тогтоох ёстой. Харилцан бие биенээ нөхөх гэдэг нь ялгаатай боловч зөвхөн эдийн засаг, соёлын ур чадвар байхад л болно. Энэхүү ялгаа нь тодорхой үндсэн шинж чанарын ялгаа биш, харин харилцан бүцийн ялгаа юм. Өөр өөр нутаг дэвсгэрийн эдийн засаг, соёлын бүтэц онцлог шинж чанартай, хамтын ажиллагаа, харилцааны салбарын орон зайтай байж, ялгарах шинжийн хэлбэрээ хадгалан үлдэж чадна, мөн адил нийтийн шинж чанартай шинэ бүцийн чадварлаг тогтолцоог хэрэгжүүлж болно. Өөр өөр нутаг дэвсгэрийн ялгагдах шинжийг харилцан үйл ажиллагааны аргаар бие биеэ ойлгож, төгс сайн зохицсон шинэ бүцийн элементийг бий болгож, түүнтэй хослуулан холбох үйл явц нь чадварлаг нөхөх явц болно. Орчин үеийн нийгэмд, хүний ахуй, соёлын амьдрал нь үндсэндээ бүцийн чадварлаг элемент бөгөөд хүний ахуй соёлын амьдрал өөр өөр нутаг дэвсгэрт харилцан адилгүй онцлогтой байдаг. Эдгээр онцлогт тэдгээрийн зарим агуулгад орон нутгийн харилцан бие биенээ чадварлаг нөхөх далд боломж байдаг. Эдгээр онцлог ямар орчинд байж, урьдчилсан нөхцөл байдалд хэрхэн хандах талаар салбарын хамтын ажиллагааг бүх нийтээрээ хөгжүүлэх идэвхтэй хүчин зүйлийг бий болгох, эдийн засаг, соёл болон улс хоорондын харилцааны талаар эрдэм шинжилгээ-судалгааны дүгнэлт хийхээс гадна олон нийтийн хэвлэл, мэдээллийг чухалчлан сурталчилж, тайлбарлан таниулах замаар баталгаажуулан, мэргэжлийн үүргээ биелүүлэх хэрэгтэй байна. Зөвхөн орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллага түүнийг боловсруулан олон түмэнд дамжуулан түгээхдээ газар зүйн бүсээр хуваан авч, орон нутгийн ард олонд хүртээх хэрэгтэй. Орон нутгийн эдийн засаг, соёлын онцлогийг харгалзан хэсэг бүлэг байгуулан шийдвэрлэвэл үүнийг орон нутгийн хэвлэлийн байгууллагууд үндсэндээ дамжуулан түгээх болно. Иймээс орон нутгийн

хэвлэлийн байгууллагуудын тусгал, эдийн засаг, соёлын салбарын онцлог талыг харуулсан давуу орчинтой байдаг. Түүний зэрэгцээ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд тухайн газрын нийгэм, олон нийтийн онцлог шинж, орон нутгийн эдийн засаг, соёлын үнэ өртгийн талаар тайлбарлан таниулж, үнэлгээ дүгнэлт хийх, мөн онцгой нэр хүнд, итгэлийг олсон байх хэрэгтэй. Харилцан адилгүй өөр өөр нутаг орны хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа мөн, эдийн засаг, соёлын өвөрмөц онцлог орчин, хүрээнд бүхэлдээ нэгдэж, цаашдаа эдийн засаг, соёлын салбарын үзэл санааг шинээр бүрэлдүүлж болох юм. Тухайн орон нутгийн эдийн засаг, соёлын өвөрмөц онцлогийг хадгалан хамгаалаад зогсохгүй бас орон нутгийн хамтын ажиллагаанд нутаг тус бүрийн эдийн засаг, соёлын өвөрмөц онцлогийг харилцан нөхөх талаар хамтран ажиллах, хэвлэл мэдээллийн байгууллагууд бүгдээрээ хамтран ажиллаж дамжуулан тараах үйл ажиллагаа явуулах нь чухал зорилт билээ.

XXI зууны ЗХА-ийн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хэрэгжүүлэх шаардлагын тухайд, орон нутаг тус бүрийн хэвлэл, мэдээллийн байгууллага түүхэн үүрэг, хариуцлагыг үүрэх болно. Харилцан хамтран ажиллах арга хэлбэр, дамжуулан тараах хүчин чадлыг ашиглан нийгмийн хөгжлийн салбарт түлхэц болох нь бид бүхний үүрэг билээ.

Нэгд. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан ЗХА-ийн бүс нутгийн эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны хүрээнд харилцан мэдээлэл солилцох мөрийн хөтөлбөртэй байх хэрэгтэй. Энэ мөрийн хөтөлбөр харилцан адилгүй орон нутгийн эдийн засаг, соёлын талын мэдээллийг бүхэлд нь нэгтгэж чадвал үр дүнтэй болох ба мөн тухайн нутгийн нийгмийн хөгжлийн талын мэдээлэл, ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны гишүүн бүрийн нийтийн сурвалж материал байх ёстой. Ийм орчинд орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагууд үүнийг салбар салбараар дамжуулан түгээх, улмаар агуулгыг нэгтгэн дамжуулах, түгээн нэвтрүүлэх арга ажиллагаа нь нээлттэй чөлөөтэй байх, орон нутгийн хүн бүрт хүртэх үзэл санааны нийгмийн мэдээллийг дэвшүүлэн тавих хэрэгтэй. Үүний зэрэгцээ өөр өөр газар нутгийн нийгмийн хөгжлийн байдалд санаа тавих, харилцан солилцсон мэдээг хадгалах талаар дүрэм журам тогтоох, мэдээлэх хэмжээг тогтоох, хамтын ажиллагааны хүрээнд хоорондоо солилцох мэдээллийг сайжруулах хэлбэрийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Цаашид орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны төвшин, аль нэг хэвлэлийн байгууллага мэдээг дамжуулан тараах явцад чухам ямар

мэдээ томоохон байр суурь эзэлж буйг үзэх, иймэрхүү мэдээний байр суурь аль салбарын хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг харах хэрэгтэй.

Хоёрт. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаагаар, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд санал бодлоо солилцож, нийгмийг тодорхойлох чадварыг харилцан нэмэгдүүлэх хэрэгтэй. Өөр өөр газар нутгийн эдийн засаг, соёлын хамтын ажиллагаа нь хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, өөрийн улс төр, эдийн засаг, соёл хийгээд нийгмийн амьдралын уламжлал, онцлогийг хадгалан, нийтийн эрх ашгийг нийтээрээ хөгжүүлэх шаардлагын дагуу тэгш эрх, зохирол, хэв журам нь бүс нутгийн хамтын ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх үндсэн нөхцөл байх болно. ЗХА-ийн бүс нутаг, ялангуяа “ЗХА-ийн бүс нутгийн орон нутгийн засаг захиргааны тэргүүн нарын нийгэмлэг”-ийн гишүүн улс орныхон хоорондоо ойртон нягтарч, харилцан бие биенээ нөхөх эдийн засгийн бүтэц, соёлын үндэс суурьтай байна. Иймд хамтын ажиллагааг хөгжүүлэх давтагдашгүй өвөрмөц давуу чанар, далд нөөц бий. Тасралтгүй өөрчлөгдөх олон улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдалд, бүс нутгийн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхдээ цаг үеийн ороо бусгаа байдлыг өөрсдөө мэдрэн тодорхойлох талаар хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Бүс нутгийн хамтын ажиллагааны талаархи мэдээг хэвлэлээр дамжуулан танилцуулахдаа энэ талын үүрэг хариуцлагыг чухалчлан хүлээх хэрэгтэй болно, орон нутгийн дотоодын болон гадаадын олон талын ээдрээтэй нөхцөл байдлыг анхааран мэдээгээ боловсруулах, бүс нутаг тус бүрийн хөгжилд үүссэн тэнцвэргүй байдлыг анхааралдаа авч, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны сувгаар салбар хоорондын арга хэмжээ авч, нийгмийн байдлыг үзүүлсэн мэдээг урьдчилан харуулж, мэдээтэйгээ холбон дамжуулж, шинэ мэдээний тусламжтайгаар хэвлэлээр танилцуулбал мэдээлэл бүхэлдээ үр дүнтэй болж, орон нутгийн бүтээн байгуулалтын бодлогыг холбон нийлүүлэх, аливаа харилцааг дамжуулан нэвтрүүлэх байгууллагын журам, хамтран ажиллах салбараа тодорхойлж бүхэлд нь хэлбэржүүлэх явдал маш чухал юм.

Гуравт. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд санал бодлоо солилцож, салбараа хөгжүүлэн дүр төрхөө босгох хэрэгтэй. Дамжуулан түгээх судлалыг үүсгэсэн хүний нэг Лажасфейрд /дуудлагаар.-орч./ үзэхдээ, “Нийгмийн байр суурийг мэдээллээр дамжуулан олон түмэнд хүртээх чадвартай байж, тэр арвин баялаг нөлөөний хүчийг нэвтрүүлж болно, нийгмийн зарим нэг зүйл,

үзэгдэл, үзэл санаа, үйл ажиллагаа нь олон нийтийн шимтэн үзэх, харах төв болж, ингэснээр нийгмийг бүхэлд нь санаа зовоосон байр суурь, нөлөөнд хүргэдэг” гэжээ. ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн талаар санал бодлоо солилцох, хамтран ажиллах явдал нь энэ бүс нутгийн улс орон бүрийн хамтын үйл хэрэг мөн, зөвхөн улс орон бүрийн Засгийн газрын шийдвэрийг дэмжих нь зайлшгүй төдийгүй улс орон бүрийн өргөн олон түмний идэвхтэй үнэлгээ маш чухал. Хэвлэл мэдээллийн байгууллага бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа нь ЗХА-ийн бүс нутгийн эдийн засаг, нийгмийг хамтаараа хөгжүүлэх олон нийтийн дуу хоолойг ашиглан хамтын хүчин чармайлгаар босгох хэрэгтэй байна. ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаа бүс нутгийн үйл хэрэгт чухал байр эзэлж, өргөн олныг идэвхтэй татан оролцуулж, асар том хүрээнд, олон улсын нийгэмд ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны дэлхийн нөлөөллийг тодорхойлон, ЗХА-ийн бүс нутгийн арвин баялаг, хэтийн төлөвийг хамтын ажиллагааны хөгжлийн хэлбэр дүрсийг шавах хэрэгтэй байна.

Дөрөвт. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаагаар дамжуулан, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд харилцан мэдээллийн албан үүргийн тогтолцоог хамтран бүрдүүлэх нь зайлшгүй чухал. ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагаа нь эдийн засгийн талаар санал солилцохдоо тодорхой агуулгатай хамтын ажиллагаатай байж, ингэснээр эдийн засгийн салбарын үйл ажиллагаа бүхэлдээ хамтын ажиллагааны татах, хөдлөх үүргийг гүйцэтгэнэ. Эдийн засгийн боловсруулсан төлөвлөгөөний шинжлэх ухаанч чанар, эдийн засгийн үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх шинж чанар, эдийн засгийн мэдээллийг оновчтой зөв дэмжих нь зайлшгүй чухал юм. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын орон нутгийн хамтын ажиллагаанд мэдээ солилцох суваг байгуулах нь мэдээгээр үйлчлэх системийн нэг болох ёстой.

Нөгөөтэйгүүр, орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагуудын тус бүрийн мэдээ солилцох үйл ажиллагаан дахь үйлчилгээний ур чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Цаашид тус бүс нутгийн хэвлэл мэдээллийн мэдээний үйлчилгээний системийг холбох алхам хийж, тал бүрээс нь эдийн засгийн мэдээг бүрэн дамжуулж, хамтын ажиллагааны орон зайг дүүргэж, эдийн засгийн нөхцөл байдал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэлбэржүүлэн тогтоож, хөрөнгө оруулалтын байдал, зах зээлийн хэтийн төлөв зэрэг мэдээгээр үйлчилж, харилцан дамжуулж, олны хүртээл болгомоор байна.

Тавд. Хэвлэл, мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаагаар дамжуулан ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд соёлын эх сурвалж, үндэс суурийг байгуулмаар байна. Үүнд “соёлын

материаллаг нөөц” гэж хэлэх нь хоёр талын утга санаатай. Нэг талаас, ЗХА-ийн бүс нутгийн салбарын хамтын ажиллагаанд, эдийн засгийн дүр төрх, эдийн засгийн үйл ажиллагааны өөрийн нь соёлын шинж чанар, үйлдвэрлэлийн өртгийн материаллаг нөөц, бүтээгдэхүүний эдийн засаг, соёлын буюу зах зээлийн эдийн засаг, соёлын материаллаг нөөцийг хэлж болно. Нөгөө талаас, ЗХА-ийн хамтын ажиллагааны салбарт, соёлын олон төрлийн материаллаг нөөцийн хүчин зүйлийг нийтээрээ хөгжүүлэх үйлдвэрлэлийг нэгтгэн нөлөөлөх, тухайлбал, нийгмийн ухамсар, амьдралын үзэл баримтлал, үндэсний уламжлал, орон нутгийн онцлог, түүхийн гэрэл сүүдэр, хүний соёлын орчин гм. ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны шууд нөхцөл нь газар зүйн ойр дөт байрлал, эдийн засгийн бүтэц харилцан бие биенээ нөхөх чадвартай, иймд хамтын ажиллагааны үндэс суурийг гүнзгийрүүлэх нь эдийн засаг, соёл болон түүний олон төрлийн соёлын харилцааны харилцан ойр шинж чанар мөн. Иймээс харилцан ойр шинж чанар хамтын ажиллагааны салбарыг хөгжүүлэхэд үйлдвэрлэлийн асар том материаллаг нөөцийн хүчин чадал буйг илтгэж байна. Олон нийтийн хэвлэл мэдээлэл соёлын материаллаг нөөцийг хадгалах, уламжлан авах, нээн хөгжүүлэх, бүхий л талын хариуцлагыг тогтоох бус, өөр өөр соёлын нөлөө, орчинтой хэвлэл мэдээллийн байгууллагуудын идэвхийг дэмжих, орон нутгийн соёлын материаллаг нөөцийг урамшуулах салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар ур чадвараа нэмэгдүүлэх, соёлын нөөцийг дахин бий болгох хүчин чадлаа бүрэн дүүрэн өргөжүүлэн хөгжүүлэх, ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг зөв зохистой, тогтвортой, бат бөх байгуулан соёлын материаллаг нөөцийн үндэс суурийн асар том нуугдмал далд хүчийг бүтээн байгуулж болно.

ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны гол чухал салбар нийгмийн хөгжлийн үзэл санаа мөн. “ЗХА-ийн бүс нутгийн Засгийн газрын тэргүүн нарын нийгэмлэг”-ийн гишүүн орнуудын хамтын ажиллагаа ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа үлгэр жишээ байх ёстой. Гишүүн 5 орны бүс нутгийн төв сонинд нийтлэгдсэнээр, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа бүтээн байгуулалтын шинжтэйгээр хэрэгжиж, улам бүр том хүрээнд ЗХА-ийн бүс нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааны ололт амжилтын туршлага болж байгаа нь цаашид ЗХА-ийн бүс нутгийн эдийн засгийн болон нийгмийн хөгжилд түлхэц болох, хэвлэл мэдээллийн байгууллагуудын гүйцэтгэх түүхэн үүрэг юм.

Хятад хэлнээс орчуулсан Ч.Батцэцэг